



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 14 (491)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай*
- *Нийслэлийн шүүхийн танхимын тэргүүнийг томилох тухай*
- *Прокурорын мэргэжлийн зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн даргыг томилох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2007 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2007 оны дөрөвдүгээр сарын 14

№14 (491)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

190.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 54	337
191.	Нийслэлийн шүүхийн танхимын тэргүүнийг томилох тухай	Дугаар 55	342
192.	Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 59	342
193.	Прокурорын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 60	342
194.	Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 61	342
195.	Прокурорын мэргэжлийн зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн даргыг томилох тухай	Дугаар 62	343
196.	Зарим хүмүүсийг аймаг, сум дундын болон нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 63	343
197.	Зарим шүүгчийг сэлгэн ажиллуулах тухай	Дугаар 64	343
198.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 72	344

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

199.	Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 03	344
------	---	-----------	-----

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 03 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, хөдөө аж ахуй, боловсрол, соёл урлаг, шинжлэх ухаан, эрүүл мэнд, эрчим хүч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдал, гааль, гадаад харилцаа,

мэргэжлийн хяналт, статистик, хэвлэл мэдээлэл, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Бүткейн Байболат - Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Засаг даргын Тамгын газрын дарга
2. Чойжамцын Батжаргал - ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

3. Даваагийн Бүдханд - Дундговь аймгийн Луус сумын малчин
4. Хахааны Давис - Нийслэлийн ОСНАА "Толгойт-ИНК" ХК-ийн захирал



5. Онгошийн Нигамет - Баян-Өлгий аймгийн Цагааннуурын худалдааны чөлөөт бүсийн ерөнхий менежер

6. Аргын Сайлау - Баян-Өлгий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

7. Дамбадаржаагийн Тогтохжаргал - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Ахмадын хорооны дарга

8. Рэнцэндоржийн Цэгмэд - Нийслэлийн Боловсролын газрын албаны дарга

9. Дугаржавын Чулуунбаатар - Хэнтий аймгийн Хэрлэн сумын өндөр настан, төр захиргааны байгууллагын ахмад ажилтан

10. Зайгны Шерхан - Баян-Өлгий аймаг дахь Гаалийн газрын дарга

“АЛТАН ГАДАС” ОДОНГООР:

1. Пагваажавын Алтанцог - ШУА-ийн Физик техникийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

2. Өөдөсийн Амаржаргал - Баянхонгор аймгийн Баянхонгор сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга

3. Жуанганы Аят - Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын өндөр настан, ахмад эдийн засагч

4. Хайсанхүүгийн Баасанцэрэн - МУБИС-ийн Багшийн сургуулийн дуу хөгжмийн дидактикийн багш

5. Бэгзсүрэнгийн Бадамсүрэн - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга

6. Туваанжавын Батнасан - Говь-Алтай аймгийн үйлдвэрлэл, худалдааны “Ентүм” ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч

7. Оохнойн Батсайхан - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн секторын эрхлэгч

8. Жүгдэрийн Батчулуун - Архангай аймгийн Жаргалант сумын Засаг дарга

9. Галтын Бат-Эрдэнэ - Төв аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

10. Нурын Беибитхан - Баян-Өлгий аймаг дахь Монгол Алтайн нурууны хамгаалалтын захиргааны дарга

11. Мөнхооройн Борхүүхэн - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 11 жилийн 1 дүгээр сургуулийн хичээлийн эрхлэгч

12. Гончигийн Ганболд - Монгол Улсаас АНУ-д суугаа Элчин сайдын яамны зөвлөх, Консулын хэлтсийн дарга

13. Давхарын Гончигсүрэн - Дархан-Уул аймгийн өндөр настан

14. Түгелтайн Гүлмаги - Баян-Өлгий аймгийн 11 жилийн 4 дүгээр ахлах сургуулийн газар зүйн багш

15. Ганбаатарын Гэрэлт-Од - Үндэсний статистикийн газрын дэд дарга

16. Абилханы Даримхан - Баян-Өлгий аймгийн ИТХТ-ийн нарийн бичгийн дарга

17. Лэгшидийн Дашням - Увс аймгийн Сагиль сумын Засаг даргын Тамгын газрын түшмэл

18. Гомбын Доржпалам - Нийслэлийн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний “Мон Со Баян” ХХК-ийн ерөнхий захирал

19. Чүрэмийн Дунай - Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч

20. Балдангийн Дүгэрсүрэн - Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

21. Ахыгийн Дүйсенби - Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч

22. Ласарын Жамбалдорж - Говь-Алтай аймгийн Ардын дуу бүжгийн “Алтай” чуулгын хөгжимчин

23. Хамангийн Жамылаш - Нийслэлийн Баянгол дүүргийн 5 дугаар хорооны өндөр настан, ахмад санхүүч

24. Сопийн Камелхан - Баян-Өлгий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн “Мөнгөн Алтай” ХХК-ийн сантехникийн инженер

25. Хадан Пхагвасүрэн - Төв аймгийн Бүрэн сумын дунд сургуулийн бага ангийн багш

26. Чойзонгийн Лонжид - Увс аймгийн Улаангом сумын өндөр настан, ахмад санхүүч

27. Улагбаны Мамбар - Баян-Өлгий аймгийн Толбо сумын Засаг даргын Тамгын газрын түшмэл

28. Дочингийн Махбал - Нийслэлийн Баянзүрх дүүргийн “Тэгээ” бүрэн дунд сургуулийн бага ангийн багш

29. Есикбайн Молдахан - Баян-Өлгий аймгийн Бугат сумын өндөр настан, Ахмадын хорооны дарга

30. Цэрэнбадамдын Мөнхбаатар - Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Рашаант багийн Засаг дарга

31. Дашнямын Мөнх-Амгалан - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 70 дугаар цэцэрлэгийн менежер

32. Тогтохын Мөнхбаяр - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Ардчилсан Намын дарга

33. Шоранбайн Муталив - Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын малчин

34. Аюушийн Нанзад - Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлого, зохицуулалтын хэлтсийн ажилтан

35. Цогбадрахын Нарандэлгэр - Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төвийн захирал

36. Камелханы Нургайв - Баян-Өлгий аймгийн Татварын хэлтсийн дарга

37. Дугарсүрэнгийн Оюун - Нийслэлийн Баянгол дүүргийн 51 дүгээр сургуулийн монгол хэлний багш

38. Ендонжугнайн Өнөборгил - Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын референт

39. Очирын Пүрэв - БСШУЯ-ны харьяа Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

40. Алахайн Рахадал - Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын "Ахтолхын" хоршооны агропаркийн эрхлэгч, Монгол Алтай судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

41. Чимэдийн Санжаасүрэн - Монгол Улсаас БНЭУ-д суугаа Элчин сайдын яамны аж ахуйн эрхлэгч-жолооч

42. Базарын Санжмятав - Монгол Улсаас БНФУ-д суугаа Элчин сайдын яамны зөвлөх

43. Рахметийн Сураган - МҮОНРТ-ийн Баян-Өлгий аймаг дахь салбарын ерөнхий захирал

44. Чулууны Тунгалаг - Их Британийн Хүүхдийг ивээх сангийн Монгол дахь хөтөлбөрийн захирал

45. Хызырын Халиасхар - Баян-Өлгий аймгийн хөдөө аж ахуйн "Мурал" ХХК-ийн захирал

46. Сахабагийн Хыдырпатша - Баян-Өлгий аймаг дахь Монгол Английн хамтарсан "Аватекс-Кайнар" ХХК-ийн гүйцэтгэх захирал

47. Аманбайн Хиялхан - Баян-Өлгий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн онолын багш

48. Жулдызбайн Хуандаг - Авто замын хяналт судалгааны төвийн хяналтын инженер

49. Ибрайн Хуатай - Баян-Өлгий аймгийн "Адилет" сонины ерөнхий эрхлэгч, "ULTV" студийн ерөнхий редактор

50. Даваагийн Хүдрээ - Нийслэлийн Налайх дүүргийн 2 дугаар хорооны өндөр настан, ахмад уурхайчин

51. Мажигийн Хүрлээ - ШУТИС-ийн Сүхбаатар аймаг дахь салбар Технологийн сургуулийн захирал

52. Должингийн Цогоо - Архангай аймгийн Өгийнуур сумын малчин

53. Доржийн Цэндсүрэн - НХХЯ-ны харьяа Улсын асрамжийн газрын дарга

54. Ендонгийн Шатар - УБТЗ-ын Сайншанд дахь Эрчим хүч, ус хангамжийн 2 дугаар ангийн боловсон хүчин

55. Лодойн Эрдэнэ - Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын 11 жилийн сургуулийн захирал

56. Жамбалдоржийн Эрдэнэчимэг - Монголын эмэгтэйчүүдийн холбооны ерөнхийлөгч

ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНГООР:

1. Хурманханы Авдкерим - Баян-Өлгий аймгийн Цагдаагийн хэлтсийн ахмад ажилтан

2. Цэрэндоржийн Батцоож - ШШГЕГ-ын харьяа Хорих 433 дугаар ангийн дарга, хурандаа

3. Цамбын Ганболд - Хөвсгөл аймгийн Онцгой байдлын хэлтсийн ахлах байцаагч

4. Диваанамсангийн Дэмчиг - ТЗҮААЭГ-ын гадна талбайн үйлчлэгч, ахмад сэргийлэгч

5. Дашзэвэгийн Зоригтбаатар - ТЕГ-ын 8 дугаар хэлтсийн ажилтан, хошууч

6. Дэндэвийн Пүрэвдавуу - Нийслэлийн Онцгой байдлын газрын албаны дарга, дээд ахмад

7. Чүлтэмсүрэнгийн Төмөрхуяг - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дээд ахмад

8. Зундуйн Төрмөнх - Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа

9. Цэгмидийн Тунсаг - Төрийн тусгай хамгаалалтын газрын орлогч, хамгаалалтын хэлтсийн дарга, хурандаа

10. Чадраагийн Цог - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын дэргэдэх Цэргийн штабын офицер, дэд хурандаа



ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Цэрэнжанцангийн Адъяасүрэн - Нийслэлийн Баянгол дүүргийн "Ундарга" хувийн дунд сургуулийн хичээлийн эрхлэгч
2. Галсангийн Алтангэрэл - Хэнтий аймгийн Баянмөнх сумын малчин
3. Дисдаабазарын Алтанцэцэг - Нийслэлийн Баянгол дүүргийн 18 дугаар хорооны Засаг дарга
4. Кадирханы Амангажы - Баян-Өлгий аймгийн геологи, уул уурхайн "Кайнар-Вольфрам" ХХК-ийн ахлах мастер
5. Сураубайн Аманжол - Баян-Өлгий аймгийн Буянт сумын холбооны салбарын монтёр
6. Баадайн Арвисан - Нийслэлийн Баянгол дүүргийн 9 дүгээр хорооны өндөр настан, ахмад тариаланч
7. Жамбын Баатар - Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын 11 жилийн дунд сургуулийн захирал
8. Доржжүүгийн Бадамдорж - ХААИС-ийн Экологи, технологи, хөгжлийн сургуулийн багш
9. Лхаасүрэнгийн Байгалмаа - Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын 11 жилийн 1 дүгээр сургуулийн захирал
10. Намсрайн Байгалмаа - Нийслэлийн статистикийн газрын тээвэр, холбоо хариуцсан мэргэжилтэн
11. Баасанхүүгийн Батбаяр - Нийслэлийн статистикийн газрын ахлах мэргэжилтэн
12. Сүмрэвийн Батбаяр - Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын 8 жилийн сургуулийн физикийн багш
13. Дандарын Батмөнх - Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хэлтсийн дарга
14. Хавдольн Бегзат - Баян-Өлгий аймгийн Толбо сумын Ахмадын хорооны дарга
15. Чүлтэмдоржийн Буянцэцэг - Нийслэлийн Баянгол дүүргийн 2 дугаар хорооны Засаг дарга
16. Жетмэгийн Гүлжан - Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын статистикч бага эмч
17. Модонгийн Даваажав - ШШГЕГ-ын харъяа 401 дүгээр энгийн асрагч
18. Гэндэнгийн Дамдинсүрэн - Нийслэлийн Налайх дүүрэг дэх Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн мастер багш
19. Есерханы Даулетхан - Баян-Өлгий аймгийн хөдөө аж ахуйн "Мөнгөн-Алтай" ХХК-ийн хүний нөөцийн менежер
20. Ядамсүрэнгийн Долгор - Нийслэлийн Хан-Уул дүүргийн "Буянт-Ухаа" цогцолбор сургуулийн бага ангийн багш
21. Думаагийн Дорж - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 67 дугаар сургуулийн дуу хөгжмийн багш
22. Натарын Дуламсүрэн - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн
23. Хонжыгийн Жаухей - Баян-Өлгий аймгийн Татварын хэлтсийн бичээч
24. Равжаагийн Жигжидсүрэн - Архангай аймгийн Боловсрол соёлын газрын жолооч-нярав
25. Талайн Керейбай - Баян-Өлгий аймгийн Сагсай сумын малчин
26. Жумалханы Күлмесхан - Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 8 дугаар цэцэрлэгийн багш
27. Сагайн Күлтай - Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сум дахь хувийн мал эмнэлгийн малын эмч
28. Аванбайн Кулыза - Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын үйлчлэгч
29. Дашдоржийн Ичинхорлоо - Төв аймгийн Борнуур сумын 11 жилийн дунд сургуулийн биеийн тамирын багш
30. Мажайн Лесхан - Ховд аймгийн Ховд сумын ИТХТ-ийн нарийн бичгийн дарга
31. Жамбын Лхагва - Нийслэлийн Налайх дүүрэг дэх Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн инженер багш
32. Билисбайн Муса - Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Засаг даргын орлогч
33. Авдильн Набидолда - Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын ЗДТГ-ын даамал
34. Халзхүүгийн Наранчимэг - ХИС-ийн Олон улс судлалын сургуулийн тэнхимийн эрхлэгч
35. Бадейн Ниетбек - Баян-Өлгий аймгийн "Эрчим" ХК-ийн гагнуурчин
36. Калитаны Нуртай - Ховд аймгийн Үенч сумын 11 жилийн сургуулийн орос хэлний багш
37. Дугарын Ойдов - Хэнтий аймгийн Баянмөнх сумын малчин
38. Анын Оюун - Нийслэлийн худалдаа, үйлчилгээний "Ансен" ХХК-ийн менежер

39. Бат-Очирын Оюунцэцэг - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 50 дугаар сургуулийн сургалтын менежер

40. Дорждадамбын Ринчиндорж - ХААИС-ийн Биологийн нөөцийн менежментийн сургуулийн багш

41. Ишжамцын Саруул - МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн багш

42. Ансаганы Сейл - Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 1 дүгээр ахлах сургуулийн биеийн тамирын багш

43. Дашнямын Солонго - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн

44. Сейлханы Тойнбай - Баян-Өлгий аймгийн Алтанцөлц сумын өндөр настан, малын ахмад эмч

45. Мижиддоржийн Тунгалаг - Нийслэлийн Хан-Уул дүүргийн "Буянт-Ухаа" цогцолбор сургуулийн орос хэлний багш

46. Жайшандагвын Тунгалаг - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 106 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

47. Ралдийн Хишигбүрэн - ТТХГ-ын хангалт үйлчилгээний хэлтсийн үйлчлэгч

48. Даваагийн Хишигням - Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн

49. Малтайн Хуат - Дархан-Уул аймаг дахь "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХК-ийн диспетчер инженер

50. Болырбайн Хурманбек - Баян-Өлгий аймгийн Сагсай сумын өндөр настан, ахмад малчин

51. Авирмэдийн Цогзолсүрэн - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ИТХТ-ийн дарга

52. Тогоогуржавын Цэдэнбал - Монголын сонсголын согогтой иргэдийн "Шинэ элч" холбооны тэргүүн

53. Кукээгийн Чулуунцэцэг - ХИС-ийн орос судлалын тэнхмийн багш

54. Жажайн Шайзада - Баян-Өлгий аймгийн Алтай сумын багийн Засаг дарга

55. Төмөрийн Энэбиш - Баян-Өлгий аймгийн Буянт сумын 11 жилийн сургуулийн бага ангийн багш

56. Баасанхүүгийн Эрдэнэсан - Барилгын коллежийн мастер багш

57. Бямбажавын Чимэдцэз - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хорооны иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Батхүүгийн Амардорж - ШШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газрын тусгай тасгийн дарга, хурандаа

2. Ванягийн Батболд - Нийслэлийн Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт сургалт иргэний хамгааллын асуудал хариуцсан офицер

3. Шархүүгийн Булган - ШШГЕГ-ын харьяа Хорих 409 дүгээр ангийн дарга, хурандаа

4. Дашзэвэгийн Ганхуяг - ШШГЕГ-ын Авдрант дахь Хорих 403 дугаар ангийн дарга, хурандаа

5. Дамдэнсүрэнгийн Дамдинцэрэн - ШШГЕГ-ын харьяа Цэгдан хорих 461 дүгээр ангийн дарга, хурандаа

6. Будын Жамбалдорж - ТТХГ-ын харуул хамгаалалтын албаны дэд ажилтан, ахлах ахлагч

7. Гончигийн Лхагвасүрэн - ТТХГ-ын 04 дүгээр хэсгийн ахлах ажилтан, дэд хурандаа

8. Цэвээний Манийхаан - ШШГЕГ-ын Амгалан дахь Хорих 421 дүгээр ангийн хэсгийн дарга, дэд хурандаа

9. Мөнхбаатарын Цэнд - ШШГЕГ-ын харьяа Цэгдан хорих 461 дүгээр ангийн боловсон хүчин, сургалт эрхэлсэн дэд дарга, дэд хурандаа

10. Самдангийн Эрдэнэ - ТЕГ-ын 1 дүгээр газрын хэлтсийн дарга, хурандаа

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 03 дугаар сарын 21-ний өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Нийслэлийн шүүхийн танхимын тэргүүнийг томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь заалтыг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Цэвээндоогийн Өрнөндэлгэрийг Нийслэлийн шүүхийн Иргэний хэргийн танхимын тэргүүнээр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 03 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1, 58.2 дахь заалтыг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн өөрөө хүсэлт гаргасан тул Бат-Очирын Бямбасүрэнг Орхон аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчийн, Хас-Очирын Эрдэнэтуяа, Хишигтийн Мөнхжаргал нарыг Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Огшоогийн Эрдэнэтогтохыг Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас, төрийн өөр ажил, албан тушаалд томилогдох болсон тул

Лувсандашийн Амарсанааг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Гаажидын Дэлгэрбямбыг Баянхонгор аймгийн шүүхийн шүүгчийн, Дагвын Жамбалсүрэнг Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Банзрагчийн Оюунцэцэгийг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Борын Дэнсмааг Хэнтий аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 03 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

Прокурорын мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнээс чөлөөлөх тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Прокурорын байгууллагын тухай" хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь заалтыг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Прокурорын мэргэжлийн зөвлөлийн гишүүн Ж.Эрдэнэбаатар өөрийн хүсэлтээр прокурорын албан тушаалаас чөлөөлөгдсөн, нарийн бичгийн

дарга П.Даарийжав тэтгэвэрт гарсан тул прокурорын мэргэжлийн зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн даргын албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 03 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.4, 32.6 дахь заалтыг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Нямжавын Туяаг Ховд аймаг дахь сум

дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд улируулан, Лувсандашийн Амарсанааг Дархан-Уул аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 03 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар хот

Прокурорын мэргэжлийн зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн даргыг томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Прокурорын байгууллагын тухай" хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь заалтыг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн Прокурорын мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн даргаар Улсын ерөнхий прокурорын

газрын Бодлого төлөвлөлт, гадаад харилцааны хэлтсийн хяналтын прокурор С.Дамчаасүрэн, гишүүнээр Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх ажиллагааны хяналт тавих хэлтсийн дарга Д.Баянжаргал нарыг тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 03 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг аймаг, сум дундын болон нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалтыг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Гаажидын Дэлгэрбаямыг Өмнөговь аймгийн шүүхийн шүүгчийн, Дагвын Жамбалсүрэнг Увс аймгийн шүүхийн шүүгчийн, Банзрагчийн Оюунцэцэргийг Хөвсгөл аймгийн шүүхийн шүүгчийн, Борын Дэнсмааг Хэнтий аймгийн шүүхийн шүүгчийн, Гомбодоржийн Ганбаатарыг Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Цанжаагийн Үйтүмэнг Говь-Алтай аймаг дахь сум

дундын шүүхийн шүүгчийн, Базаррагчаагийн Наранчимэгийг Говьсүмбэр аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Доржсүрэнгийн Алтаннавчийг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Лхагвацэрэнгийн Гэрэлмааг Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Нямаагийн Баярхүүг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Дүгэрхүүгийн Эрдэнэчимэгийг Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 03 дугаар сарын 23-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

Зарим шүүгчийг сэлгэн ажиллуулах тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Дорнод аймаг дахь Хэрлэн сумын шүүхийн шүүгч Түмээгийн Байгалаа, Лхамсүрэнгийн Батжаргал, Хөхөөгийн Санжидмаа нарыг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд, Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Лхамсүрэнгийн Ганчимэг,

Батдолгорын Энхбаатар, Лхүндэвийн Наранбаяр, Ганбаатарын Уртнасан нарыг Дорнод аймаг дахь Хэрлэн сумын шүүхийн шүүгчийн албан тушаалд, Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Жагарын Байгалааг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус сэлгэн ажиллуулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 04 дүгээр
сарын 06-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар
хот

Зарим хүнийг одон, медалиар
шагнах тухай

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо байгуулагдсаны 15 жилийн ойг тохиолдуулан тус хороонд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурьдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Өөдөөгийн Цэрэндорж - Сонгуулийн ерөнхий хорооны ахлах референт

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Дугардоржийн Баяндүүрэн - Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Батмөнхийн Маймөнх - Сонгуулийн ерөнхий хорооны референт

2. Бямбаагийн Оюумаа - Сонгуулийн ерөнхий хорооны референт

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2007 оны 03 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар
хот

Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж
Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох
заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг
хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 19.45 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүдэд Н.Жанцан, П.Очирбат, Ж.Болдбаатар, Ж.Амарсанаа, Ч.Дашням /илтгэгч/, Д.Наранчимэг, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Д.Ламжав, Р.Бурмаа, Ж.Бямбаа, Ч.Хурц, С.Авирмэд, Л.Цог, П.Болд нар болон Улсын Их Хурлын даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Хууль зүйн бэйнгын хорооны дарга Ц.Мөнх-Оргил, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Н.Лувсанжав, Нэгдүгээр нарийн бичгийн дарга Ж.Нарантуяа нар оролцлоо.

Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж Авлигын эсрэг хуулийн эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулсны дараа өөрчлөлт, засвар хийсэн нь, мөн Ашигт малтмалын тухай хуулинд

эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулсны дараа өөрчлөлт, засвар хийгээд Улсын Их Хуралд танилцуулаагүй нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 13 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Ламжав, Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн Р.Бурмаа нар 2006 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн мэдээллэдээ:

"Батлагдсан хуульд хийсэн эцсийн найруулгыг Улсын Их Хуралд сонсгосны дараа Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр засвар хийдэг, эсвэл найруулгыг Улсын Их Хуралд сонсгодоггүй. Ийм нөхцөл үүсээд байхад Улсын Их Хурлын дарга үг хуулийг ёсчилдог хууль бус үйл ажиллагаа нэг бус удаа тохиолдох боллоо. Энэхүү хууль бус үйл ажиллагаа нь хуралдаан даргалагчийн зүгээс өөрийн бүрэн эрх, чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй явдалтай шууд холбоотой байна.

Энэ нь Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлийн "Хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална", Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Улсын Их Хурал нь хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ", Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн доторх "Үндсэн хуульд... нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтуудыг зөрчиж байна, хянаж өгнө үү" гэжээ.

Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн Р.Бурмаа 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд гаргасан нэмэлт тайлбартаа:

"2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан Авлигын эсрэг хууль 2006 оны 9 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хурлын дарга гарын үсэг зурснаар ёсчлогдсон бөгөөд уг хууль нь мөн оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн Төрийн мэдээлэл сэтгүүлийн 35 дугаарт албан ёсоор хэвлэгдэн гарчээ.

Улсын Их Хурлын чуулганаар батлан эцсийн найруулга хийсэн 7 дугаар сарын 8-ны өдрийн хуулийг 9 дүгээр сарын 08-ны өдөр гарын үсэг зурж, ёсчилсон хуультай харьцуулахад редакцийн шинжтэй хуулиар зөвшөөрөгдсөн засвараас гадна хуулийн агуулга, бодлого, зарчмын шинжтэй өөрчлөлтүүдийг хийсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн зүйлийг ноцтой зөрчсөн байна гэж үзэж байна. Үүнийг хуулийн хувийн хэрэгт авагдсан материалууд, Улсын Их Хурлын гишүүдэд тараасан болон Төрийн мэдээлэл сэтгүүлд албан ёсоор хэвлэгдсэн эхээс харж болно.

Энэ нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 51.1, 51.2 дахь заалтыг зөрчжээ. Үүнд, "Улсын Их Хурлын дарга болон Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга энэ дэгийн 51.1.1, 51.1.2 дахь хэсэгт заасны дагуу эцсийн найруулгыг хянахдаа түүний агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр зөвхөн найрлага, үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засвар хийж болно" гэж заасан эрх мэдлийг хэтрүүлэн агуулга, зарчмын өөрчлөлтүүдийг хийсэн байна.

Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална", Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн "Улсын Их Хурал... "хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах" эрхийг өөрийн онцгой эрхэд хадгалж шийдвэрлэнэ гэснийг тус тус зөрчиж Улсын Их Хурлын бүрэн эрхэд халдсан гэж үзэж байна.

Мөн Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд... нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтуудыг зөрчсөн байна гэж үзэж байна" гээд Улсын Их Хурлаас батлагдсан болон ёсчлогдсон хуулийн 26.1, 15.3 заалтын зарчмын өөрчлөлтүүдийг хүснэгтээр харьцуулан хавсаргасан байна.

"Хуульд агуулга, зарчмын өөрчлөлт оруулж, бие даасан хараат бус байх ёстой байгууллагыг Улсын Их Хурлын даргын бүрэн эрхэд харьяалуулж болохоор болгожээ. Үүнд:

Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан Улсын Их Хурлын даргын бүрэн эрхэд:

"11.1.6. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд Улсын Их Хурлаас тавих хяналтыг зохион байгуулах;

11.1.16 хуульд заасан бол Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, дэд даргыг томилох санал гаргаж байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх" гэж заасан байдаг.

Авлигын эсрэг хуульд Авлигатай тэмцэх газрын дарга, дэд даргыг Монгол Улсын Ерөнхийлөгч нэр дэвшүүлнэ, Авлигатай тэмцэх газрыг байгуулахдаа Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг үндэслэнэ гэж заасан. Гэтэл хуулинд хийсэн өөрчлөлт нь уг байгууллагын дарга, дэд даргыг томилох саналыг Улсын Их Хурлын дарга гаргахаар болгожээ.

Төрийн албан хаагч гэсэн тодорхойлолтод бүх шатны сонгуульд нэр дэвшигчийг оруулж мөн хуулийн бусад заалтыг өөрчилснөөр төрийн албанд ороогүй сонгуульд нэр дэвшигчийг мөрдөн мөшгөх заалт болгон хувиргажээ” гээд хуулийн 4, 3.1.1, 3.1.2, 3.1.4, 11.3, 11.4, 11.5 заалтад оруулсан өөрчлөлт, засварыг харьцуулан харуулсан байна.

“Хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд “Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагад байнга, эсхүл түр хугацаагаар томилогдсон буюу сонгогдсон, цалинтай болон цалингүй ажилладаг, түүнчлэн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон захиргааны албан тушаал эрхэлдэг, төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтан, сонгуульд нэр дэвшигчид энэ хууль хамаарна” /4.1/ гэж байсныг цалинтай цалингүй ажилладаг гэдэг нь хасагдаж ОНРТВ-ийн Үндэсний зөвлөлийн дарга, ерөнхий захирал нэмэгдсэн байна. Цалинтай ба цалингүй ажилладаг төрийн албан хаагчид хуулийн үйлчлэлд хамаарна гэж Монгол Улс нэгдэн орсон НҮБ-ын авлигын эсрэг конвенцийн тодорхойлолтод заасан байдаг.

Мөн Авлигатай тэмцэх газрын бүрэн эрхэд хэрэг бүртгэлт нэмэгдсэн” байна гэжээ.

Хоёр. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 2 дугаар хорооны оршин суугч, иргэн Ж.Бямбаа, Нийслэлийн Баянзүрх дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Ч.Хури, Баянгол дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн С.Авирмэд, Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн Л.Цог, Баянзүрх дүүргийн 13 дугаар хорооны оршин суугч, иргэн П.Болд нар 2006 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:

“Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлгийн 2 дахь хэсэгт заасан: “...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Гуравдугаар бүлгийн 25.1.1-д “...хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах онцгой бүрэн эрх Улсын Их Хурлын мэдэлд хадгална” гэснийг тус тус зөрчин өөрийн эрх мэдлээ

хэтрүүлэн Улсын Их Хурлын чуулганаар 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр эцэслэн баталсан Ашигт малтмалын тухай хуульд дур мэдэн ихээхэн өөрчлөлт оруулсан байна. Тухайлбал, энэ хууль анх батлагдахдаа 40 хуудас, 10 бүлэг, 70 зүйлтэй байсан бол Улсын Их Хурлын дарга гарын үсэг зурсны дараа 43 хуудас, 11 бүлэг, 66 зүйлтэй болсны гадна Улсын Их Хурлын гишүүдийн баталсан 27 заалтыг хасч, гишүүдээр хэлэлцэгдээгүй 24 заалтыг нэмж оруулсан байна. Уг хуулийн 5.5 дугаар заалтад орд ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухай байсан бол Улсын Их Хурлын даргын засварласнаар орд эзэмшигч болон хувирч төрийн өмчийн эзэн болсон мэт ойлголт төрүүлж байгаа нь Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2-т харшилсан агуулгатай болсон гэж үзэж байна.

Ашигт малтмалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд, мөн л цөөнгүй засварыг нэгэнт баталсны дараа оруулжээ. 1997 оны хуулийн дагуу бусдад тараагаад олон жил болсон хайгуулын болон ашиглалтын лицензийг эздэд нь хэвээр үлдээх зорилгоор, нэгэнт хүчингүй болгосон 1997 оны хуулийг буцаан үйлчлүүлэх шийдвэр гаргасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлгийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын агуулгыг зөрчсөн үйлдэл болжээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар баталсан хуулийг Улсын Их Хурлын дарга ингэж засварлах нь Улсын Их Хурлын хууль тогтоох эрхэд халдсан, эрх мэдлээ хэтрүүлэн, албан тушаалаа урвуулан ашигласан гэж үзэж байгааг ханан хэлэлцэж, зохих шийдвэр гаргаж өгөхийг хүсье” гэжээ.

Гурав. Эдгээр иргэдийн өргөдлийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Амарсанаа хүлээн авч хянаад Үндсэн хуулийн цэцэд маргаан янхан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4/-г заасан өргөдөл, мэдээллийн шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр 2007 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан байна.

Доргов. Үндсэн хуулийн цэцийн гишүүний дээрх тогтоолыг эс зөвшөөрч иргэн Д.Ламжав, Р.Бурмаа нар 2007 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр, иргэн Ж.Бямбаа, Ч.Хурц, С.Авирмэд, Л.Цог, П.Болд нар 2007 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр Үндсэн Хуулийн цэцэд дахин хандаж дараах агуулгатай гомдол гаргасан байна.

1. Иргэн Д.Ламжав, Р.Бурмаа нарын нэрийг бичиж Д.Ламжав гарын үсэг зурсан 2007 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн гомдол:

"Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан Үндсэн хуулийн цэцийн гишүүний тогтоолыг зөвшөөрөхгүй байгаагаа тэмдэглээд "Улсын Их Хурлын шийдвэрийн эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулах, ёсчлох, уг шийдвэрийг Ерөнхийлөгчид илгээх журмыг дэгийн 51.1-51.4 заалтуудаар зохицуулсан, Улсын Их Хурлын шийдвэрт эцсийн найруулгыг хожим хийх, улмаар Улсын Их Хуралд танилцуулахгүйгээр ёсчлох эрх хэмжээ Улсын Их Хурлын даргад олгогдоогүй байна.

Улсын Их Хурлын 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийн товчлолсон хэсэгт Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж 19 хуулийн эцсийн найруулгыг уншиж, орсон зарим засвар, өөрчлөлтүүдийг танилцуулсан тухай эдгээр хуулийн нэрийг тоочин тэмдэглэсэн байна. Энэ өдөр хаврын чуулган хаагдсан ба намрын чуулган 2006 оны 10 дугаар сарын 02-нд нээгдсэн. Энэ хооронд Улсын Их Хурлын ямар нэгэн чуулган болоогүй байна.

2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр 19 хуулийн эцсийн найруулгыг Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга биш Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж танилцуулсан нь, 6.3/-д томъёолсон хууль тогтоомж зөрчсөн үйлдэл болжээ.

Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаан дээр хурал даргалагч Ц.Нямдоржийн хэлсэн үгнээс иш татъя гээд,

Авлигын эсрэг хуулийн редакцийг та бүхэнд тараасан. Энэ хууль 11 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ. Их зовлонтой юмнууд нүдэнд үзэгдээд байна билээ. Засварууд цаашдаа

хийгдэнэ. Тэгэхдээ одоо та бүхэнд тараасан төслийн талаар санал хэлэх гишүүн байна уу. Лүндээжанцан дарга өчигдөр үзсэн гэсэн, Мөнх-Оргил дарга үзсэн гэсэн. Энэ түвшинд Тамгын газар үзсэн, болно гэж үзсэн байна. Гэхдээ дотор нь юм байгаа байх. Саяны татварын хуулиудтай ярьдаг зарчмаараа редакцийг сонссон гэж тооцох уу. За. Болохгүй бол намрын чуулган хүртэл барина. Болвол цаашаа явуулна. Хуульд редакци хийх хугацаа байхгүй учраас би иймэрхүү эрх Их Хурлаас аваад байгаа юм".

2006.07.06-нд батлагдсан Авлигын эсрэг хуулийн "Эцсийн найруулга" 2006.07.19, 2006.09.05, 2006.09.08-нд хийгдэж, Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж түүнийг нь 2006.09.11-нд бүрэн ёсчлон Ерөнхийлөгчид илгээсэн гэдгийг Улсын Их Хурлын архив дахь Авлигын эсрэг хуулийн хувийн хэрэг нотолж байна. Ийнхүү Улсын Их Хуралд танилцуулагдаагүй бөгөөд Улсын Их Хурлаас зохих ёсоор зөвшөөрөл аваагүй эцсийн найруулга /Авлигын эсрэг хууль/ Төрийн мэдээлэл /2006.09.21, № 35/464/-д нийтлэгдсэн байна.

Цэцийн бага суудалд гаргаж буй энэхүү гомдлыг хэлэлцэн, бидний нэхэмжлэлийн дагуу Үндсэн хуулийн Цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн магадлал гаргаж өгөхийг Та бүгдээс итгэн хүсч байна. Бид нарт нотлох бусад баримт хангалттай цугларсан байгаа бөгөөд түүнийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргаж тавина" гэжээ.

2. Иргэн Ж.Бямбаа, Ч.Хурц, С.Авирмэд, Л.Цог, П.Болд нар 2007 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд дахин гаргасан гомдолдоо:

"...Цэцийн гишүүн нь бидний мэдээллийг урьдчилан шалгах үүрэгтээ хариуцлагагүй хандаж дутуу гүйцэтгэлээ. Хэрэв уг мэдээллийг зохих ёсоор нягтлан үзсэн бол Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хурлын чуулганаар баталсан Ашигт малтмалын тухай хуулийн эцсийн найруулгыг хянахдаа хуулийн бодлого, зарчим, агуулгыг алдагдуулсан дараахь засвар хийснийг хялбархан ойлгох байсан юм. Үүнд

1. Бүхэлд нь баталсан хуульд "1.1 Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмалын эрэл, хайгуул хийх ашигт малтмал ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэжээ. Гэтэл Улсын Их Хурлын дарга "1.1 энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж засаад ...эрэл, хайгуул хийх, ...хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчинг хамгаалах гэснийг хасчээ. Ийнхүү байгаль орчинг геологи, уул уурхайн салбарт хамгаалах онцгой чухал асуудлыг хуулийн зорилтоос хассан нь бүтцийн шинжтэй засвар биш гэж үзэж байна.

Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 51 дүгээр зүйлийн 51.1.2, 51.1.3-д заасны дагуу эцэслэн хянасан найруулгыг Улсын Их Хурлын чуулганд танилцуулах үүрэгтэй. Гэтэл дэгийн уг заалтыг зөрчин хуулийн эцсийн найруулгыг мөн оны 8 дугаар сарын 05-ны өдөр хянасны дараа ямар өөрчлөлт, засвар оруулснаа Улсын Их Хурлын чуулганд танилцуулаагүй байна.

Эдгээр байдлыг үндэслэн бид Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж нь дээрх үйлдлүүдээрээ Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", 21 дүгээр зүйлд заасан "Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална", Гуравдугаар бүлгийн 25.1.1-р зүйлд заасан "...хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах онцгой бүрэн эрх Улсын Их Хурлын мэдэлд хадгалагдана" гэснийг тус тус зөрчсөн гэж үзэж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн Ашигт малтмалын тухай хуулийн төсөл, уг хуралдааны бичлэг, 2006 оны 8 дугаар сарын 05-ны өдөр уг хуулийн төсөлд Улсын Их Хурлын дарга Ц.Нямдоржийн биечлэн хийсэн засварын эх хувь зэргийг Улсын Их Хурлын архиваас гаргуулан авч нотолгоо болгох, дээрх нотолгоонуудыг үндэслэн Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гаргаж өгнө үү" гэжээ.

Тав. Монгол Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж 2007 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 1/902 дугаар албан бичгээр ирүүлсэн тайлбартаа:

"1. Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын 2006 оны 14 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны Дэг"-ийн 51.1, 51.2-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаас баталсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулгыг хянах, Улсын Их Хуралд танилцуулсны үндсэн дээр өсчилдөг.

Ийнхүү эцсийн найруулгыг хянах явцад Улсын Их Хурлын дарга болон Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга хуулийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр зөвхөн найрлага, үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийх эрхтэй.

2. Нэр бүхий иргэдийн өргөдөлд дурдсан Авлигын эсрэг хууль, Ашигт малтмалын тухай хуулийн эцсийн найруулгыг Улсын Их Хурлын 2006 оны хаврын чуулган өндөрлөх үеэр нэгдсэн хуралдаанд танилцуулахад миний бие дээр дурдсан бүрэн эрхийнхээ хүрээнд эдгээр хуулийн эцсийн найруулгыг үргэлжлүүлэн хянаж засварлах шаардлагатайг мэдэгдсэний үндсэн дээр хуулийн агуулга, зарчим, бодлогыг өөрчлөхгүйгээр зохих засварыг хийж өсчилсөн болно.

Эдгээр хуулийн хувийн хэрэгт миний биечлэн засвар хийсэн тэмдэглэл байгааг Цэцэд хүргүүлсэн материалаас тодорхой танилцах боломжтой. Мөн Улсын Их Хурлын Тамгын газрын ажигтнуудын засвар хийсэн тэмдэглэл ч тодорхой байгаа.

3. Дээр дурдсан хуулиудын эцсийн найруулгад засвар хийснээр нэр томъёог жигдэлсэн, хуулийн зүйл, заалтуудын тоорондын логик холбоо, уялдааг хангасан, үг хэллэгийн найруулгыг сайжруулсан, зүйлийн гарчигтай агуулгыг нийлүүлсэн, хоёрдмол санааг арилгасан, шаардлагатай зүйл, заалтын ишлэлийг татсан, бүтцийн хувьд ойлгомжтой, дэс дарааллыг нь цэгцтэй болгосон бөгөөд чингэхдээ хуулийн

зохицуулалтын бодлогыг чанд хадгалж чадсан гэдэгт бүрэн итгэлтэй байна.

4 Дээрх хуулиудын найруулгыг Улсын Их Хурлын гишүүдэд урьдчилан тараасны үндсэн дээр Улсын Их Хурлын чуулганы 2007 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанд дахин танилцуулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүдээс хуулиудын талаар зарчмын шинжтэй санал гараагүй болно.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргааныг хянан шийдвэрлэхдээ хуулийн төслийн санаачлагчаас оруулсан бодлого, үзэл баримтлал, төслийн хэлэлцүүлгийн явцад орсон өөрчлөлт, Улсын Их Хурлын холбогдох байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд хэлэлцсэн тэмдэглэл, эцсийн найруулгыг хийсэн баримт материалыг хянан үзэж, бодлого, зарчмыг хадгалсан байдлыг онцлон анхаарахыг хүсье.

Энэхүү маргааныг Цэцийн хуралдаанд хэлэлцэн шийдвэрлэхэд намайг төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Н.Луванжав, Нэгдүгээр нарийн бичгийн дарга Ж.Нарантуяа нарыг томилж байгаагаа үүгээр мэдэгдэж байна.

Өргөдөл гаргасан иргэдээс Цэцийн илтгэгч гишүүнд болон Цэцэд гаргасан тодорхой үндэслэлүүдийн талаар тухай бүрт нь итгэмжлэгдсэн төлөөлөгчид тайлбар өгөх болно” гэжээ.

Зургаа. Улсын Их Хурлын даргын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Н.Луванжав, Нэгдүгээр нарийн бичгийн дарга Ж.Нарантуяа нар 2007 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 3/197 дугаар албан бичгээр ирүүлсэн нэмэлт тайлбартаа:

“1. Ашигт малтмалын тухай болон Авлигын эсрэг хуулийн эцсийн найруулгыг 2006 оны 7 дугаар сарын 20-нд Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулсан. Энэ өдрийн хуралдаанд хаврын чуулганаар баталсан 40 гаруй хууль, бусад шийдвэрийн эцсийн найруулгыг танилцуулсан бөгөөд

цаг хугацааны хувьд олон том хуулийн эцсийн найруулгыг нэгэн зэрэг хийх боломжгүй байсан. Энэ байдлыг Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд танилцуулж, эдгээр хууль, шийдвэрийн төслийн эцсийн найруулгыг ажлын хэсгийн ахлагч, Байнгын хорооны дарга нартай зөвшилцсөний үндсэн дээр хийх эрх авсан.

Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 51.2-т заасан эрх болон 7 дугаар сарын 20-ны нэгдсэн хуралдаанаас олгосон эрхийн хүрээнд найрлага, үг хэллэг, бүтэц дэс дарааллын шинжтэй засвар хийж Ашигт малтмалын хуулийн эцсийн найруулгыг Ажлын хэсгийн ахлагч Д.Одхүү, гишүүн Ц.Дамиран нарт, Авлигын эсрэг хуулийн эцсийн найруулгыг хууль санаачлагч Улсын Их Хурлын дэд дарга Д.Лүндээжанцан, Байнгын хорооны дарга Ц.Мөнх-Оргил нарт танилцуулж өөр саналгүй гэсэн тул ёсчилсон.

Ер нь хууль, шийдвэрийн эцсийн найруулга хийх, танилцуулах ажиллагааг хуулиар биш, Улсын Их Хурлын тогтоолоор баталсан чуулганы хуралдааны дэгээр зохицуулдаг бөгөөд энэхүү ажиллагаа нь хууль тогтоох үйл ажиллагааны техникийн горим тул энэ талаар гарах саналын зөрөлдөөн нь Үндсэн хуулийн цэцээр хянан шийдвэрлэгдэх маргаан биш, Улсын Их Хурал дотооддоо хэлэлцэж шийдвэрлэх асуудал юм. Иймд Үндсэн хуулийн цэц өөрт нь үл харьяалагдах асуудлыг хэлэлцэж аливаа шийдвэр гаргахгүй гэдэгт найдаж байна.

2. Авлигын эсрэг болон Ашигт малтмалын тухай хуульд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгд зааснаар эхний ээлжийн засварыг Улсын Их Хурлын Тамгын газар /Ерөнхий нарийн бичгийн дарга/ хийж эцсийн хувилбарыг Улсын Их Хурлын даргад өгсөн. Энэхүү хувилбар дээр Улсын Их Хурлын дарга ажилласан. Иймд аль засварыг хэн хийснийг нарийвчлан ялгаж тогтоох шаардлагатай. Тухайлбал Тамгын газрын хийсэн засварыг Улсын Их Хурлын дарга хийсэн гэж үзэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргаж болохгүй гэж үзэж байна.

3. Эдгээр хуулиудад хийсэн засвар, найруулга нь Улсын Их Хурлаас хуулийг батлахдаа баримталсан агуулга, бодлого, зарчимтай зөрчилдсөн гэдгийг зөвхөн Улсын Их Хурал, түүний гишүүд дүгнэх

бүрэн эрхтэй. Авлигын эсрэг болон Ашигт малтмалын тухай хуулийг 2007 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд дахин танилцуулсан бөгөөд энэ үеэр дээрх хуулийн эцсийн найруулга /редакти/-ын талаар гишүүдээс нэг ч гомдол, санал гараагүй. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурал болон гишүүд хуулийн эцсийн найруулга Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг, 7 дугаар сарын 20-нд олгосон эрхийн хүрээнд явагдсан, эдгээр хуулиудад агуулга, бодлого, зарчмын шинжтэй өөрчлөлт ороогүй гэдгийг эцэслэн хүлээн зөвшөөрсөн болно.

Тухайлбал, Ашигт малтмалын тухай хуульд нэг заалт орхигдон ёсчлогдсон тухай асуудлыг Улсын Их Хурал дахь Ардчилсан намын Зөвлөлөөс бичгээр Улсын Их Хуралд хандан тавьж, ийнхүү орхигдсон заалтыг хуульд нэмж оруулах санал тавьсныг Улсын Их Хурлын 2007 оны 01 дүгээр сарын 31-ний нэгдсэн хуралдаанд танилцуулж, Ашигт малтмалын тухай хуулийг ёсчилсон байдлаар нь орхигдсон заалтыг нэмж оруулан Улсын Их Хурлын гишүүдэд урьдчилан тараасны үндсэн дээр гишүүд судалж, тодорхой санал байвал дараагийн хуралдаанд авч үзэхээр шийдвэрлэсэн юм. Энэ үеэр мөн Хууль зүйн байнгын хорооны даргын саналаар Авлигын эсрэг хуулийг ч энэ маягаар авч ярихаар болсон. Үүний дагуу уг хуулиудыг Улсын Их Хурлын гишүүдэд 2007 оны 1 дүгээр сарын 31-нд хувиан тарааж, танилцуулан Улсын Их Хурлын 2007 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн. Энэ үеэр Улсын Их Хурлын гишүүдээс эдгээр хуулийн талаар агуулга, бодлого, зарчмын шинжтэй засвар хийсэн тухай ямар нэг санал шүүмжлэл гараагүй болно.

4. Өргөдөл гаргагчаас Үндсэн хуулийн цэцэд нэмж гаргасан "Ашигт малтмалын хуульд Улсын Их Хурлын дарга Ц.Нямдоржийн хийсэн засвар ба түүнээс үүдсэн үр дагавар" гэсэн нэртэй хүснэгтийн 1 дэх баганын 3-8 дахь мөрөнд бичсэн бүх заалтууд Улсын Их Хурлын гишүүдэд тараасан эцсийн найруулгын заалтаас өөр болсон байна. Хуулийн эцсийн хэлэлцүүлгийн төсөл, эцсийн найруулгын төслийн аль алинд нь ийм заалт байгаагүй бөгөөд зарим заалтыг өргөдөл гаргагчид санаанаасаа зохион бичиж агуулгыг өөрчилжээ.

Тухайлбал, уг хуулийн 4 дэх мөрөнд "Тус хуулийн 19.2 Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 19.1-д заасан ажиллагааг гүйцэтгэсний

үндсэн дээр өргөдлийг бүртгүүлснээс хойш ажлын 3 өдөрт дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана" гэжээ. Гэтэл эцсийн хэлэлцүүлэг болон эцсийн найруулгын төсөлд "өргөдлийг бүртгүүлснээс хойш" гэсэн үг өгүүлбэр байхгүй байна.

Өөрөөр хэлбэл өргөдөл гаргагчид чухам ямар төслүүдийг харьцуулан ийм зүйл бичсэнийг ойлгох аргагүй байна.

Иймд хуулийн зарим зүйл, заалт алга болсон, огт байхгүй зүйл нэмэгдсэн, зарчмын шинжтэй засвар оруулсан гэдгийг Цэцэд хүргүүлсэн үндсэн материалаас нягтлан үзэхийг хүсье.

5. Өргөдөл гаргагчид Ашигт малтмалын тухай хуулийн 1 дүгээр зүйлээс "хайгуулын талбай болон уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай" гэсэн заалтыг хассан гэжээ. Эдгээр үгүүдийг хассан нь үнэн бөгөөд энэ нь дараахь шалтгаантай юм. Үүнд

а/ Хуулийн зорилтод ийм үгүүд оруулсан боловч хуулийн бусад зүйл, заалтад "хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай" холбогдсон ямар нэгэн зүйл, заалт, зохицуулалт байгаагүй тул хассан. Хуульд "уурхайг хаах үед тавигдах шаардлага" гэсэн 45 дугаар зүйл байгаа боловч энэ зүйлд "уурхайн эдэлбэр орчиг хамгаалах" тухай ямар ч заалт алга.

б/ "Хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалах" асуудал нь бүхэлдээ ашигт малтмал ашиглахтай холбоотойгоор гардаг олон төрлийн эрх зүйн харилцааны өнөүүхэн хэсэг байдаг тул тэдгээрийг хуулийн зорилт гэсэн зүйлд онцгойлон заавал оруулах шаардлагагүй, "ашиглах" гэсэн ойлголт дотроо багтаж зохицуулагддаг гэсэн утгаар нь үг хэллэгийн засвар хийсэн.

6. 1997 онд батлагдсан Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 13 дугаар хэсэг, Улсын Их Хурлын 2001 оны 6 дугаар сарын 21-ний 61 дүгээр тогтоолоор баталсан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.14-д "Эцсийн хэлэлцүүлгээр баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг хэлэлцүүлэг дууссанаас хойш ажлын 6 өдөрт багтаан Улсын Их Хуралд танилцуулна. Эцсийн найруулгыг танилцуулах ажлыг Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцна" гэж тус тус

заасан байсан бөгөөд энэхүү заалтын хүрээнд холбогдох засварууд байнга хийгдэж ирсэн.

Ийм найруулгын засвар урьд өмнө батлагдаж мөрдөж байсан бүх хуулиудад хийгдэж байсан бөгөөд үүнийг Улсын Их Хурлын архивт хадгалагдаж байгаа хууль, шийдвэрийн "хувийн хэрэг"-тэй танилцан магадлаж болно.

Өөрөөр хэлбэл найруулгын засвар зөвхөн энэ Их Хурал, Ц.Нямдорж даргын үед шинээр бий болсон зүйл биш, 1990 оноос хойшхи бүх Бага, Их Хурал, тэдгээрийг удирдаж байсан дарга нарын үед хийгдэж ирсэн, хууль тогтоох ажлын нэгэнт уламжлагдан тогтсон практик гэдгийг тэмдэглэж байна" гэжээ.

Иргэн Д.Ламжав, Р.Бурмаа нар Үндсэн хуулийн цэцэд анх гаргасан мэдээлэлдээ Улсын Их Хурлын дарга Ц.Нямдоржийг Улсын Их Хурлын даргаас огцруулах үндэслэлтэй талаар дурьдсан боловч энэ асуудлаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгээгүй, нөгөө талаар иргэн Ж.Бямбаа, Ч.Хурц, С.Авирмэд, П.Болд нар 2007 оны 3 дугаар сарын 01-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн нэмэлт мэдээлэлдээ Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай дүгнэлт гаргахын зэрэгцээ түүнийг огцруулах үндэслэл байгаа эсэх талаар дүгнэлт гаргуулах хүсэлт тавьсантай холбогдуулж дараахь зүйлийг тэмдэглэх нь зүйтэй гэж үзсэн болно. Үүнд:

Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар... хянан шийдвэрлэнэ", Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Иргэд Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай асуудлаар Цэцэд өргөдөл, мэдээлэл ирүүлнэ" гэж тус тус заасныг үндэслэн иргэдийн өргөдөл, мэдээллээр Цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 5-д заасан албан тушаалтнуудыг огцруулах, эгүүлэн татах асуудлыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсэн хэлэлцэх үндэслэлгүй гэж үзсэн болно.

Иргэн Ж.Бямбаа, Ч.Хурц, С.Авирмэд, П.Болд нар 2007 оны 3 дугаар сарын 01-ний өдөр

ирүүлсэн дээрх нэмэлт тайлбартаа Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж хуулинд засвар хийсэн үйлдлээр Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн гэж нэмж дурьдсан байна.

ҮНДЭСЛЭЛ:

1. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2006 оны 7 дугаар сарын 06-ны өдөр 93.0 хувийн саналаар баталж, 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулсан Авлигын эсрэг Монгол Улсын хуульд 2006 оны 9 дүгээр сарын 08-ны өдөр, мөн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр 83.7 хувийн саналаар баталж, 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдөр эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулсан Ашигт малтмалын тухай хуульд 2006 оны 8 дугаар сарын 05-ны өдөр тус тус агуулга, бодлого, зарчмын болон найруулга, үг хэллэг, дараалал, бүтцийн чанартай олон тооны засвар, өөрчлөлтийг Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж хийсэн нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны тэмдэглэл болон эдгээр хуулийн хувийн хэрэг дэх баримтууд бусад нотлох баримтаар нотлогдож байна.

Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж Улсын Их Хурлын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-ийн "Улсын Их Хурал ...хуралдаанаар хуулийн төсөл, ...хэлэлцэх, ...батлах, шийдвэр гаргахдаа Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг баримтална", мөн Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор баталсан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн Тавин нэгдүгээр зүйлийн 51.4-ийн "Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулгыг энэ дэгийн 51.1.3-т заасны дагуу Улсын Их Хуралд танилцуулснаас хойш Улсын Их Хурлын дарга ажлын 3 өдрийн дотор түүнд гарын үсэг зурж ёсчилно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Ийнхүү Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын тогтоолоор баталсан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн холбогдох заалтыг зөрчсөнөөрөө Монгол Улсын Үндсэн хуулийн

Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн"; Хорьдугаар зүйлийн "...хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална"; Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн "хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах" нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэх асуудал болох тухай заалтыг тус тус зөрчсөн байна.

Харин Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд... нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах үндэслэл байгаа эсэх талаар дүгнэлт гаргах асуудлыг Үндсэн хуулийн цэц эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтээр хэлэлцэх тул өргөдөл гаргагч иргэдийн энэ талаар тавьсан хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНООС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1.Авлигын эсрэг хууль, Ашигт малтмалын тухай хуулийн эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулсны дараа агуулга, бодлого, зарчмын болон найруулга, үг хэллэг, дэс дараалал, бүтцийн чанартай олон засвар, өөрчлөлтийг хийснээрээ Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн";

Хорьдугаар зүйлийн "...хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална"; Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн "хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах" нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэх асуудал болох тухай заалтыг тус тус зөрчсөн байна.

2.Улсын Их Хурлын дарга Ц.Нямдорж Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд... нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтыг зөрчөөгүй байна.

3. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын хаврын чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Ж.БЯМБАДОРЖ

ГИШҮҮД

Н.ЖАНЦАН

П.ОЧИРБАТ

Ж.БОЛДБААТАР

Ж.АМАРСАНАА

Ч.ДАШНЯМ

Д.НАРАНЧИМЭГ

Ц.САРАНТУЯА

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс: 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 2